



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/620

Хэрлэн сум

Дэлгэрхаан сумын цэцэрлэгийн
тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрхаан сумын Цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийн хугацаа 2018 оны 8 дугаар сарын 28-ны өдөр дууссан тул, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр буюу 2023 оны 8 дугаар сарын 28-ыг хүртэл сунгасугай.

2. Сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг хэвийн явуулж, сургуулийн өмнөх боловсролын холбогдох хууль, тогтоомжийг чанар хүртээмжтэй зохион байгуулахыг тус Цэцэрлэгийн эрхлэгч (Д.Долгорсүрэн)-д, удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ